



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 04

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Сүхбаатар сумын иргэн Н.Гантуяа нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

А.Эрдэнэгэрэл

-Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

Ж.Отгонхүү


-Мэргэжлийн хяналтын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Ариундэлгэр

-Хүний нөөцийн мэргэжилтэн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

2. Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж дүгнэлт санал боловсруулан Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 02 дугаар сарын 10 -ны дотор шийдвэрлэхийг ажлын хэсгийн ахлагч /А.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА